

PLITONIT

МЭРГЭЖИЛТЭН БАЙХ АМАРХАН



ПЛИТОНИТ СТРОЙЭКСПРЕСС бүрхэлтийн хуурай цавууны хольц



Бүтээгдэхүүн нь дотоод засал хийхэд зориулагдсан:

- 60x60 см хэмжээтэй хавтан, чулуун хавтанцрыг хэвтээ гадаргуу, түүний дотор нийтийн эзэмшлийн талбай (шатны талбай, коридор гэх мэт) наах,
- үүрэн бетон блок суурилуулах (өргөтгөсөн шавар бетон, хөөс бетон, агааржуулсан бетон).

Үүнийг "дулаан шал" системтэй суурь болон гадаа ашиглахыг хориглоно. Нийтийн эзэмшлийн талбай, орон сууц, тэр дундаа сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн байгууламж (тэр дундаа эмчилгээ, урьдчилан сэргийлэх, амралт-сувиллын байгууламжуудад)-д хэрэглэж болно.

Савлагаа — 25 кг.

- Шалан дээр том хэмжээтэй чулуун хавтанцрыг суурилуулах зориулалттай
- 24 цагийн дараа явж, чигжээс хийж болно
- Барьцалдах чадвар 0,5 МПа -аас багагүй
- Үүрэн блокуудыг өрөн тавихад тохиромжтой

Бүтээгдэхүүний зарцуулалт

1 мм зузаантай гүйцэтгэх үеийн зарцуулалтын хэмжээ нь ойролцоогоор 1,3-1,4 кг/м² байна

Хавтангийн хамгийн урт талын урт, мм	108 хүртэл	109-200	201-250	251-300	300-аас эхлэн
Хусуурын ховилын гүн, мм	4	6	8	10	12
Хуурай хольцын зарцуулалт 1 м ² талбайд, кг-аас	2,65	3,98	5,3	6,63	7,95
25 кг цавуу ашиглан суурилуулсан хавтангийн талбай, м ² -аас	9,4	6,3	4,7	3,8	3,1

Ажлын нөхцөл

Ажлын явцад болон гүйцэтгэлийн дараа 3 хоногт агаар, суурь, хавтангийн температур +5 хэмээс + 30 хэмд байх ёстой. Ажлын явцад зуурмаг хольцын температур +10 хэмээс +30 хэмд байх ёстой.

Гадаргууг бэлтгэх

Өнгөлгөөний гадаргуу нь бат бэх байх шаардлагатай, ажил эхлэхээс өмнө гадаргууг тоос, шороо, тос, бүх төрлийн будаг болон цавуу, хуурах боломжтой элементүүдээс сайтар цэвэрлэх шаардлагатай. Гөлтгөнө суурь болон ус ихээр шингээдэг, гадаргууг өнгөлгөөний ажил эхлэхээс өмнө үйлдвэрлэгчийн зааврын дагуу ПЛИТОНИТ хөрсжүүлэгчээр боловсруулалт хийх ёстой. Цаашдын ажлыг хөрсжүүлэгч бүрэн хатаасны дараа хийнэ

Зуурмаг бэлтгэх

Хуурай хольцыг нийлүүлж холихдоо нийтийн усны хангамжийн усыг ашиглах боломжтой. Холих харьцаа нь 1 кг хуурай цавууны хольцод 0,17-0,21 литр (1 уут буюу 25 кг-д 4,25 - 5,25 литр) ус шаардагдана. Хуурай хольцыг тасалгааны температурт урьдчилан хэмжсэн зохих хэмжээний ус уруу хийнэ, нэгэн төрлийн жигд болтол нь 2-3 минутын турш эргэлтийн хүрд нь 600 эргэлт/мин-ээс ихгүй байх цахилгаан холигч эсвэл цахилгаан өрмийн тусламжтайгаар холино. Зуурмагийг ойролцоогоор 5 минут амраан дахин холино. Энэ үед зөвшөөрөгдсөн хамгийн дээд хэмжээний үлдсэн усыг нэмж хэрэглэж болно. Бэлэн зуурмагийг хэрэглэх хугацаа нь 4 хүртэлх цаг байх бөгөөд агаарын хэт халалт болон нэвт салхижуулалт энэ хугацааг багасгахад нөлөөлнө.

Ажлын дараалал

Бэлтгэсэн зуурмагийг суурийн гадаргуу дээр жигд тараан, гөлгөр хусуураар түрхэж ховилтой хусуураар долгион гаргах байдлаар түрхэнэ (ховилын хэмжээ нь хавтангийн хэмжээ, төрлөөс хамаарна). Зуурмагийг асгаснаас хойш 10 минутын (ажил гүйцэтгэх хугацаа) дотор өнгөлгөөний хавтанг наах боломжтой байдлаар тооцон гүйцэтгэнэ. Хэрэв хэрэглэсэн цавууны гадаргуу дээр хатсан царцдас үүссэн бол зуурмагийг гадаргуугаас хусаж аван шинээр сольж хийх шаардлагатай. Хавтанг зуурмаг дээр тавихдаа бага зэрэг эргүүлэх байдлаар сайн дарж тавина. Хавтангийн байрлалыг 10 минутын дотор засан тохируулж болно. Өрөөний агааржуулалт, дулаан, гадаргуун чийг шингээх чадвараас шалтгаалан нээлттэй ажиллах хугацаа өөрчлөгдөж болно. Хавтан нь нээлттэй залгалтаар тавьж, зохих бэхлэгээгээр (жишээлбэл, ПЛИТОНИТ-ийн хэрээс) тэгшилнэ. Өнгөлгөөний хавтанг байрлуулах үед хавтангийн ар талын овгор зузаан нь 2 мм хэмжээ нь 30х30 см-аас том хэмжээтэй тохиолдолд хавтан, гадаргуу хоёрын хооронд хоосон зай гаргахгүй байх, барьцалдахыг бат бэх болгох зорилгоор гадаргуу болон хавтангийн ар талд зуурмагаа хосолсон аргаар түрхэж хэрэглэнэ. Цавууг дээр дурдсанчлан суурь дээр хэрэглэнэ. Хавтангийн арын хэсэгт цавууг эхлээд ховилтой хусуураар түрхэж, дараа нь гөлгөр хусуураар хавтангийн бүх хэсэгт жигд тэгшилнэ. Тус хосолсон хэлбэрээр зуурмагийг ашиглах үед зарцуулалт нь 1 мм зузаантай түрхэх үед 1.4 кг/м² болж нэмэгддэг.

Анхааруулга

Өнгөлгөөний хавтанг гадаргуу дээр байрлуулснаас хойш 24 цагаас багагүй хугацааны дараа дээгүүр нь алхах, чигжээс хийж болно. Дээр заагдсан хугацаа нь орчны температур (20±2)°C, агаарын харьцангуй чийгшил (60±10)%-д үйлчлэх бөгөөд бусад үед хугацаа хэлбэлзэж болно. Ажлыг гүйцэтгэхдээ барилгын ерөнхий ажил гүйцэтгэх зааварчилга, барилга угсралтын ажилд мөрдөгдөх аюулгүй ажиллагааны зааварчилга дагаж мөрдөх ёстой. Хавтанг тавихаас өмнө дэвтээж болохгүй, хавтангийн арын хэсгийг тоос, шорооноос цэвэрлэх хэрэгтэй. Ажил гүйцэтгэх явцад зуурмагийг үе үе хольж байх ёстой. Бэлэн зуурмаг дээр нэмж ус хийхийг хориглоно.

Аюулгүй ажиллагаа

Хольц нь ОХУ-ын стандарт хэмжилзүйн газрын ГОСТ 12.1.007 стандартын дагуу аюулын 4-р (бага аюултай бодис) ангилалд хамаарна. Ажил гүйцэтгэхдээ бээлий, нүдний шил, амны хаалт хэрэглээрэй. Зуурмагийг арьс, нүдэнд хүрэхээс зайлсхийх. Нүдэнд хүргэсэн тохиолдолд нэн даруй их хэмжээний усаар зайлна. ХҮҮХДЭЭС ХОЛ БАЙЛГААРАЙ.

Тээвэрлэлт болон хадгалах нөхцөл

Хуурай хольцыг ачаа тээвэрлэх дүрмийн дагуу бүрхүүлтэй тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

Хуурай хольцтой уутыг савлагааны аюулгүй байдал, чийгээс хамгаалсан хаалттай хуурай өрөөнд хадгална. Үйлдвэрлэгчийн саванд хадгалах хугацаа нь тээвэрлэх, хадгалах нөхцөл зөрчигдөөгүй үед үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар байна.

Орц, найрлага

Элс, портланд цемент, эрдэс дүүргэгч, өөрчлөгч нэмэлт бүтээгдэхүүнүүд

Үйлдвэрлэгчийн баталгаа

Хэрэглэгч энэ зааврын тээвэрлэлт, хадгалалтын нөхцөл, зааврыг дагаж мөрдсөн тохиолдолд хольц нь

ОХУ-ын стандарт хэмжилзүйн ГОСТ Р 31356 стандарт, шаардлагад нийцэж байгааг үйлдвэрлэгч баталгаажуулж байна. Үйлдвэрлэгч нь материалтай ажиллах технологийг дагаж мөрдөхгүй байх, түүнчлэн эдгээр зааварт заагаагүй зорилго, нөхцөлд ашиглах үед хариуцлага хүлээхгүй. ГОСТ 8.579-2002 стандартын дагуу цэвэр жингийн хазайлт байна. Бүтээгдэхүүнийг бүх төрлийн иргэний барилгад ашиглахыг зөвшөөрсөн. (Аэфф<370 Бк/кг байх ОХУ-ын Цацрагийн аюулгүй байдлын стандартууд НРБ-99/2009, ариун цэврийн дүрэм, журам СанПиН 2.6.1.2523-09 нийцсэн).

Техник үзүүлэлтүүд

Дүүргэгчийн хамгийн том ширхгийн хэмжээ	0,63 мм
Цавууны үеийн хамгийн их залгааны зузаан	10 мм
Хэрэглэх усны хэмжээ 1 кг хольцод 25 кг хольцод	0,170 - 21,0 л 4,25 - 5,25 л
Ажлын температурын горим	+5°C-аас +30°C хүртэл
Нээлттэй ажиллах хугацаа, багагүй	10 минут
Хавтанг засах, тохируулах хугацаа, багагүй	10 минут
Зуурмаг хольцын амьдрах чадвар	4 цаг
Зуурмагийн ажил хийх боломжтой болох хугацаа, дараа	24 цаг
Ашиглалтын үеийн температурын горим,	+35°C хүртэл
Дарагдах үеийн тэсвэртэй байдлын марк, багагүй	M100
Хуурай агаарт 28 хоногийн түрш байлгасны дараа цавууны барьцалдах бат бөх байдал	≥0,5 МПа
Хэвийн нөхцөлд 28 хоногийн дараа агааржуулсан бетонд зуурмагийн наалдсан бат бэх байдал	≥0,3 МПа

Логистикийн мэдээлэл

Хувийн бар-код 4607013045675

Нэг багц дахь уутны тоо – 48 ширхэг